

АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

ГЭРЭЭ

№АӨҮА-2012/54

2012.05.15

Ерөнхий зүйл

Ашигт малтмалын тухай хуулийн 23 дугаар зүйлийг үндэслэн нэг талаас Ашигт Малтмалын Газар (цаашид АМГ гэнэ), нөгөө талаас ХҮ-005635 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч Улаанбаатар хотын Баянгол дүүргийн Татварын албанд бүртгэлтэй, аж ахуйн нэгжийн 9019050032 тоот гэрчилгээ, 5298679 регистрийн дугаартай "Фрийгүүд эрин" ХХК (цаашид Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэнэ) нь Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 209 тоот тушаалаар батлагдсан Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах журмыг үндэслэн Дорноговь аймгийн Сайхандулаан, Улаанбадрах сумын нутагт орших Өндөржавхлан алтны үндсэн ордын ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үеийн хийгдэх үндсэн ажлуудын хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх үе шат, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг.Гэрээний нөхцөл, хугацаа

1. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
 - а. ТЭЗҮ боловсруулахын өмнө гидрогеологийн судалгаа, дагалдах ашигт малтмалын судалгаа мөн гүйцээх хайгуулын ажлыг хийх;
 - б. Ордын нөөцөд тулгуурлан ТЭЗҮ боловсруулах;
2. Дагалдах ашигт малтмалын судалгааг 2012 оны 12 дугаар сарын 20-ны дотор хийх
3. ТЭЗҮ боловсруулахын өмнө гидрогеологийн судалгаа болон гүйцээх хайгуулын ажлын үр дүнгийн тайланг 2012 оны 12 дугаар сарын 20-ны дотор хийх
4. Орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг нөөцийн тайлан батлагдсанаас хойш хуулийн хугацаанд 2013 оны 4 дүгээр сарын 20-ны дотор АМГ-т ирүүлнэ.
5. Дорноговь аймгийн Сайхандулаан, Улаанбадрах сумын нутагт орших "Өндөр жавхлан" нэртэй газар орших алтны үндсэн ордын ашиглалтын өмнөх үйл ажиллагааг 2015 оны 04 дугаар сарын 16-ний өдөр дуусгавар болгоно

Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын зардлыг улсын төсөвт нөхөн төлөх гэрээг орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахаас өмнө Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу байгуулсан байна.
2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд ашиглалтын үед хийж гүйцэтгэх дараах ажлын зөвшөөрлийг авсан байна. Үүнд:

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

- a. Газар эзэмших зөвшөөрөл, гэрээ
 - b. Усны гэрээ
 - c. Уурхайн шав тэмдэг тавих
3. Ордыг ашиглах, эрдсийг баяжуулах, боловсруулах үед хэрэглэгдэх химийн бодис ашиглах зөвшөөрлийг авсан байна. Үүнд:

a. Боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-ний шатанд тодорхой болох:

4. Гэрээний биелэлтийн тайлан гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 48 дугаар зүйлд заасан бүхий л заалтыг хэрэгжүүлж ажиллан тайлан мэдээг хуулийн хугацаанд (1) жил тутам 2 дугаар сарын 15-нд АМГ-т ирүүлнэ.
5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний биелэлттэй холбоотойгоор АМГ-аас үзлэг, шалгалт хийж байгаа төлөөлөгчдөд холбогдох баримт, бичгүүдтэй танилцах боломж олгон, үйлдвэрлэлийн талбайд саадгүй нэвтрүүлнэ.
6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүсэлтээ АМГ-т бичгээр гаргаж болно.
7. Орд ашиглахтай холбогдсон баримт бичгийг Монгол хэл дээр үйлдсэн байна.
8. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд гарч байгаа зардлуудыг татварын албанд тушаасан тухай мэдэгдлийг тайланд тусгасан байна.
9. Энэхүү гэрээг гэрээнд заасан нөхцлөөс өөр хэлбэрээр ашиглахыг хориглоно.

Гуравдугаар зүйл. Ашигт малтмалын газрын эрх, үүрэг

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээний биелэлтийн талаар болон ашиглалтын өмнөх үйл ажиллагааны явцын тухай мэдээлэл авах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ тухай хүсэлтийг бичгээр хүргүүлнэ.
2. Энэхүү гэрээний заалтуудад өөрчлөлт оруулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг авсан байна.
3. Гэрээний заалтуудын биелэлтэд үзлэг, шалгалт хийх хүсэлтээ бичгээр хүргүүлнэ.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээний заалтуудыг, хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хариуг бичгээр хүргүүлнэ.
5. Энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг бичгээр авсан байна.


Дөрөвдүгээр зүйл. Бусад зүйл.

1. Энэхүү гэрээнд АМГ болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчид гарын үсэг зурсан өдрөөс хойш хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү гэрээний биелэлтийг ордыг ашиглалтанд хүлээн авсан комиссын дүгнэлт, шийдвэр (гэрээний заалтууд бүрэн биелсэн акт)-ийг үндэслэн гэрээлэгч талууд хамтран дүгнэж акт үйлдэнэ.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гарах үр дагаварыг бүрэн хариуцна.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний биелэлтийг АМГ-тай хамтран дүгнээгүй тохиолдолд ашигт малтмалын ХҮ-005635 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.
5. Гэрээг 3 /гурван/ хувь үйлдсэн бөгөөд 1 /нэг/ хувийг АМГ-ын Уул уурхай /нүүрсний/-н асуудал хариуцсан нэгжид 1 /нэг/ хувийг тусгай зөвшөөрөл эзэмшигч 1 /нэг/ хувийг кадастрын бүртгэлийн төвийн архивт тус тус хадгална.
6. Энэхүү гэрээний биелэлттэй холбогдон гарах маргааныг гэрээлэгч талууд харилцан тохирч шийдэх бөгөөд эс шийдэлд хүрсэн тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан:

Ашигт малтмалын газрыг төлөөлж:
Уул уурхайн судалгааны хэлтсийн
дарга.....(Ц.Даваацэрэн)



Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:

"Фрийгүүд эрин" ХХК-ийн захирал
.....(М.Баяртогтох)



Улаанбаатар хот

2012 оны 5 дугаар сарын 08-ны өдөр.

АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ГЭРЭЭНД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

2014 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу шинэчлэн бүртгэл хийгдэж байгаатай холбогдуулан нэг талаас Ашигт малтмалын газар /цаашид АМГ гэх/, нөгөө талаас Дорноговь аймгийн Сайхандулуун, Улаанбадрах сумдын нутагт орших Өндөржавхлант алтны үндсэн ордын XV-005635 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн эзэмшигч “Фрийгүүд эрин” ХХК-тай байгуулсан №АӨҮАГ-2012/54 тоот гэрээнд дараах нэмэлт өөрчлөлт оруулав.

Энэхүү нэмэлт өөрчлөлт оруулсан хавсралт нь үндсэн (№АӨҮАГ-2012/54) тоот гэрээний салшгүй хэсэг байна.

1 Дорноговь аймгийн Сайхандулуун, Улаанбадрах сумдын нутагт орших Өндөржавхлант алтны үндсэн ордын талбайн ашигт малтмалын хайгуулын XV-005635 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр дуусгавар болно.

2. Тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг үндсэн гэрээ байгуулах үед мөрдөж байсан хуулийн дагуу төлөх буюу төлбөрийн хэмжээ 1 гектар тутамд 1.5 америк доллар байна.


3. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны тухай гэрээнд Ашигт малтмалын тухай хуулийн 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтийг мөрдөж ажиллана.

4. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээнд оруулах энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө баталгаажуулж, тусгай зөвшөөрлийн хавсралтанд шинэчлэн бүртгүүлсэн тухай тэмдэглэгээ хийлгэнэ.

Ашигт малтмалын газрыг төлөөлж:

Уул уурхайн хэлтсийн дарга

..... С.Баттулга



Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:

“Фрийгүүд эрин” ХХК-ийн захирал

..... М.Баяртогтох





Хайгуулын тусгай зөвшөөрөл:

Эзэмшигч:	Фрийгүүд эрин	Олгосон огноо:	2003.04.16
Талбайн нэр:	Өндөр жавхлан	Дуусах огноо:	2015.04.16
Талбайн хэмжээ:	8281.36 Га	Барьцаалсан байдал:	---
Байршил:	Дорноговь (Сайншанд; Сайхандулаан)	Шүүхэд хэлэлцэгдэж буй эсэх:	---
Ашигт малтмал:	---	Планшетийн дугаар:	L-49-112

Хөдөлгөөн:

Код	Төрөл	Бүртгэсэн огноо	Одоогийн байдал
XV-005635-000-CI	[CI] Цэгцлэгдсэн өгөгдөл	2010.02.09	47-Албадан хийсэн хөдөлгөөнийг эцэслэх
XV-005635-001-NE	[NE] Шинэ хайгуулын тусгай зөвшөөрөл	2003.03.24	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-002-TF	[TF] Бүхэлд нь шилжүүлэх (Өмнөх эзэмшигч: Д.Батболд)	2004.02.12	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-003-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2004.04.15	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-004-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2005.04.13	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-005-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2006.03.13	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-006-EE	[EE] Хайгуулыг тусгай зөвшөөрлийг сунгах	2006.04.14	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-007-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2007.04.16	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-008-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2008.03.05	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-009-EE	[EE] Хайгуулыг тусгай зөвшөөрлийг сунгах	2008.03.27	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-010-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2009.04.17	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-011-TF	[TF] Бүхэлд нь шилжүүлэх (Өмнөх эзэмшигч: Оюу Толгой)	2009.06.22	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-012-EE	[EE] Хайгуулыг тусгай зөвшөөрлийг сунгах	2010.03.16	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-013-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2010.03.17	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-014-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2011.02.21	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-015-TPR	[TPR] Хэсэгчлэн шилжүүлснээс үүдэж багасах	2011.09.15	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-016-NMR	[NMR] Шинэ ашиглалтын тусгай зөвшөөрлөөс үүдэж багасах	2012.06.14	19-Батлагдсан өргөдлийг эцэсл

Хэвлэсэн огноо: 2015.05.07 13:59

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN



XV-005635-017-AP	[AP] Ашиглалтын өмнөх үйл ажиллагаа	2012.05.15	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-018-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2012.06.25	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-019-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2013.04.25	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-020-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2014.04.24	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-021-AP	[AP] Ашиглалтын өмнөх үйл ажиллагаа	2014.12.03	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-005635-022-EX	[EX] Хугацаа дуусах (дуусгавар болгох)		33-Эрх зүйн хяналт

Эзэмшигчийн бүртгэл:

Нэр: Фрийгүүд эрин
 Аж ахуйн нэгжийн төрөл: гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай
 Бүртгэлийн дугаар: 5298679
 Улсын бүртгэлийн дугаар #: 9019050032
 Улс: Өмнөд Солонгос
 Захирлын овог, нэр: У Сог Мин У Сог Мин

Утас: 362849/г/л, 70156050/a/
 Гар утас: 91189293, 99052065
 Факс: ---
 E-мэйл: freegooder@gmail.com

Эзэмшигчийн хаяг:

Гудамж: Энхтайваны өргөн чөлөө Альфа төв-201 тоот
 Хот: Улаанбаатар
 Аймаг/ Хот: Улаанбаатар
 Сум/ Дүүрэг: Баянзүрх
 Баг/ Хороо: 14-р хороо

Шуудангийн хайрцаг: ---
 ZIP код: ---

ТЗ-ийн солбицол:

Олон өнцөгт	#	Уртраг			Өргөрөг		
		град	мин	сек	град	мин	сек
Ex1	1	109	42	31.8	44	44	1.56
Ex1	2	109	42	31.79	44	40	0
Ex1	3	109	38	59.96	44	40	0
Ex1	4	109	38	59.96	44	42	55.35
Ex1	5	109	33	22.1	44	42	55.35
Ex1	6	109	33	22.1	44	40	0

Хэвлэсэн огноо: 2015.05.07 13:59



Ашигт малтмалын газрын
Кадастрын хэлтэс

Тусгай зөвшөөрлийн
дэлгэрэнгүй мэдээлэл
ТЗ-ийн дугаар: XV-005635

Ex1	7	109	30	1.78	44	40	0
Ex1	8	109	30	1.79	44	44	1.56

Хэвлэсэн огноо: 2015.05.07 13:59


ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ
ДУУСГАВАР БОЛСОН ТУХАЙ АКТ № 2015/06

Нэг талаас АМГ, нөгөө талаас Дорноговь аймгийн Сайхандулаан, Улаанбадрах сумдын нутагт орших Өндөржавхлан алтны үндсэн ордын XV-005635 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Фрийгүүд эрин” ХХК-тай харилцан тохиролцож 2012 оны 05 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан №АӨҮА-2012/54 тоот гэрээний үйлчлэх хугацаа дууссан тул Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах журмын 6.1.3-д заасны дагуу ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээг дуусгавар болгов.

Жич: АМГ-ын Кадастрын хэлтсийн CMCS программаас XV-005635 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг хуулбарлан хавсаргав.

УУЛ УУРХАЙН ХЭЛТСИЙН
ДАРГА С.БАТТУЛГА



2015 оны 05 дугаар сарын 06-ны өдөр